

“НҮҮДЭЛЧИН МОНГОЛ – 2022”

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ЦАХИМ КОНТЕНТЫН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл:

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” – ийн Зорилго 1-т “эх хэл, эх түүх, өв соёлыг нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар, дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно”, 1.2.11.-т “Соёлын үйлдвэрлэл, соёлын бүтээлч аялал жуулчлалыг Монголын нүүдлийн соёлын онцлогт тохируулан нутагшуулж, үндэсний загвартай болох, үндэсний үнэт зүйлийг бүтээх, хадгалах, хамгаалах, аялал жуулчлалын эргэлтэд оруулахад зориулсан мэдээллийн систем, цахим технологи нэвтрүүлнэ” хэмээн тусгасан. Мөн Монгол Улсын Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хуульд заасны дагуу Соёлын биет бус өвийг хадгалж хамгаалах, түүнийг өвлөн уламжлагчийг тодруулах, алдаршуулах, авьяас билгийг хөгжүүлэх, олон нийтэд сурталчлан, түгээн дэлгэрүүлэх зорилгоор гурван жил тутам улсын хэмжээнд зохион байгуулж байхаар хуульчлагдсан “Нүүдэлчин Монгол - 2022” соёлын биет бус өвийн их наадмыг 2022 оны 8 дугаар сарын 12-14-ны өдрүүдэд зохион байгуулах юм.

Энэхүү их наадмын хүрээнд “Нүүдэлчин Монгол” цахим контентийн уралдааныг зарлаж байна.

Хоёр. Зорилго:

- СББӨ-ийг олон нийтэд цахим контентоор дамжуулан таниулан сурталчлах, мэдлэг ойлголт түгээх,
- “Нүүдэлчин Монгол наадам”-ын зорилго, агуулга, ач холбогдолыг олон нийтэд сурталчлан түгээх, хоногшуулах
- Өсвөр насны хүүхдүүдийн дунд СББӨ-ийн цахим контент бүтээгчдийг олж илрүүлэх, хөгжүүлэх, бүтээлч санааг дэмжих
- Залуу үеийн манлайллыг хөгжүүлэх

Гурав. Хамрах хүрээ:

10-16 насны хүүхэд, залуучуудын дунд.

Дөрөв. Сэдэв

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Бүртгэл шигэчлэн батлах тухай” А/759 дүгээр Тушаалын нэгдүгээр хавсралтаар батласан “Монгол Улсын соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл”, хоёрдугаар хавсралтаар баталсан “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-д хамаарах дараах 7 ай савыг хамруулна. Үүнд:

1. Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд,
2. Ардын язгуур урлаг,
3. Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага,
4. Байгалийн болон сав шим ертөнцийн тухай уламжлалт мэдлэг, зан үйл,
5. Уламжлалт арга ухаан,
6. Мал маллах арга ухаан,
7. Уламжлалт гар урлал.

Тушаалын хавсралтыг доорх линкээс харна уу

- <http://ncch.gov.mn/ich?ItemID=2>
- <http://ncch.gov.mn/ich?ItemID=3>

Тав. Цахим контентын төрөл

- Видео (2-3 минут)
- Гэрэл зураг (1 цомог: 5-6 гэрэл зураг)
- Гар зурагт хуудас (постер)

Зургаа. Хугацаа:

2022 оны 8 сарын 01-ний өдрөөс 8-р сарын 31-ний өдөр.

2022 оны 8-р сарын 01-31-ний өдрүүдэд цахим контентийг нийгмийн сүлжээ, цахим хуудсуудад байршуулан олон нийтэд түгээх

2022 оны 9-р сарын 01-05-ны өдрүүдэд өөрийн цахим бүтээл, түүний идэвхжүүлэлтийн цахим холбоосын хамт Соёлын өвийн үндэсний төвийн info@ncch.gov.mn хаягт хүргүүлэх.

Долоо. Тавигдах шаардлага:

- “Нүүдэлчин Монгол 2022” наадмын хүрээнд СББӨ-ийг олон нийтэд сурталчилан таниулах.

- Бүтээл нь гар зураг, комикс, видео, гэрэл зургаар илэрхийлэгдэж болно.
- Гэрэл зураг нь нягтаршил, чанарын өндөр шаардлага хангасан байх. Цомог нь 5-6 гэрэл зургаас бүрдэх.
- Видео нь 2-3 минутаас хэтрэхгүй байх.
- Холбогдох гэрэл зураг, видео бичлэгийг сурталчилгааны зорилгоор ашиглах зөвшөөрлийг хавсаргах
- Бүтээл нь уралдааны чиглэл болох дурдсан сэдвийн хүрээнд байх.
- Бүтээлд сэдвийн хүрээнд нэр олгосон байх.
- Бүтээлийг цахим хуудас, нүүр ном, твиттер, инстаграм зэрэг нийгмийн сүлжээгээр олны хүртээл болсон байх.
- Бүтээлийг олон нийтэд түгээхдээ [#NUUDELCHINMONGOL2022](#) тэмдэглээг заавал ашиглах.

Найм. Шалгаруулалт:

Шалгаруулалтыг дараах бүрэлдэхүүнтэй шүүгчдийн баг хийнэ: Үүнд:

- Соёлын биет бус өвийн шинжээч
- Мэдээллийн технологийн мэргэжилтэн
- Найруулагч
- Мэргэжлийн гэрэл зурагчин
- Олон улсын хөндлөнгийн шүүгч

Жич: Тухайн бүтээл цахим орчинд олон нийтийн хандалтыг аль зэрэг татсан нь шалгаруулалтын чухал нэгэн үзүүлэлт болно.

Ес. Шагналын сан:

I байр – 1 500 000 төгрөг

II байр – 1 000 000 төгрөг

III байр – 500 000 төгрөг

Арав. Бүтээл хүлээн авах:

Бүтээлийг info@ncch.gov.mn имэйл хаягаар хүлээн авах ба имэйлийн гарчигт “Нүүдэлчин Монгол” гэж заавал бичнэ.

Хариуцах мэргэжилтэн: Б.Алтансүх

Холбоо барих утас: 9905-5643 /Ажлын өдөр, ажлын цагаар залгана уу/